

Гэрээний дугаар: ХХЗХ/202112026

**“УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХЭТ БОГИНО
ДОЛГИОНЫ РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ
МОНИТОРИНГ ХИЙХ”**

зөвлөх үйлчилгээний гэрээ

БАГЦ 1

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО


болон

МАКСИМА МЕДИА ХХК-ИЙН

хооронд байгуулсан гэрээ


(Нийт үнэд үндэслэсэн гэрээ)

2021.03.30-ны өдөр



БАТЛАВ: ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Г.ЧИНЗОРИГ /



/гарын үсэг/

БАТЛАВ: МАКСИМА МЕДИА
ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

З.ЭНХЖАРГАЛ /



/гарын үсэг/

“УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХЭТ БОГИНО ДОЛГИОНЫ
РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХӨТӨЛБӨРТ МОНИТОРИНГ ХИЙХ” зөвлөх
үйлчилгээний гэрээ

Гэрээний дугаар: ХХЗХ/202112026

2021 оны 03-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Үйлчилгээ үзүүлэх гэрээг нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо, түүнийг төлөөлж Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга З.Эрдэнэчулуун /цаашид Захиалагч гэх/, Нөгөө талаас Максима Медиа ХХК, түүнийг төлөөлж ерөнхий захирал З.Энхжаргал /цаашид Гүйцэтгэгч гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 03 сарын 30-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон “Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ”-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь “Багц 1 - Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хэт богино долгионы радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт мониторинг хийх” зөвлөх үйлчилгээг (цаашид “ажил” гэх) **91,060,035 (Ерэн нэгэн сая жаран мянга гучин тав) төгрөгөөр** (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар

Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь, бүтэц, загвар

Хавсралт №3 Голлох мэргэжилтнүүдийн мэдээлэл

Хавсралт №4 Мониторинг хийх үзүүлэлтүүд

(хүснэгтээр үзүүлсэн байдал)

Хавсралт №5 Тайлан хүргүүлэх хэлбэр, хугацаа

Хавсралт №6 Мониторинг-д хамрагдах радиогийн жагсаалт

Хавсралт №7 Төлбөрийн хуваарь

